



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Утас/Факс: (976) 7011 2857,
E-mail: nctmmgl@gmail.com

2020.12.01 № 393

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор донорын тоо эрс буурч цус, цусан бүтээгдэхүүний нөөц хомсдох эрсдэл үүсч байна.

Иймд цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

**ШИНЭ КОРОНАВИРУСТ (COVID-19) ХАЛДВАР ГОЛОМТЛОН ТАРХСАН ҮЕД
ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

1. Цус өгөлтийн тоо эрс буурч, ЦЦБ-ий нөөцийн хэмжээ буурах эрсдэл үүсч байгаа тул эмчилгээнд аль болох цус сэлбэлтийг орлох альтернатив аргыг сонгох;

2. Улаанбаатар хотод ЦССҮТ, орон нутагт ЦСТ-тэй хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ болон нөөцийн зохистой харьцааг баримтлан ажиллах;

3. Цус, цусан бүтээгдэхүүн зайлшгүй, их хэмжээгээр хэрэглэх шаардлагатай төлөвлөгөөт мэс заслыг 14 хоногоос доошгүй хугацааны өмнө мэдэгдэх, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг хатуу хөл хорионы дэглэм цуцлагдах хүртэл түр хугацаагаар хойшлуулах;

4. Ялтаст эсийн өтгөрүүлэг зэрэг удаан хугацаагаар хадгалж, нөөц үүсгэх боломжгүй бүтээгдэхүүнийг нэн шаардлагатай үед хэрэглэх, захиалахдаа нэг донороос буюу цитоферезийн аргаар (6-8 нэгж) бэлтгэсэн бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэх;

5. Цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх савыг өдөр бүр тогтмол цэвэрлэж, хлор агуулсан уусмалаар халдваргүйжүүлэх;

6. Хэрэв шинэ коронавируст (COVID-19) халдварын сэжигтэй болон батлагдсан хүн сүүлийн 14 хоногийн хугацаанд цусаа өгсөн өгүүлэмжтэй бол энэ талаар мэдээлэл авсан Эрүүл мэндийн байгууллага Цус сэлбэлт судлалын үндэсний төвд нэн даруй мэдээлэх.